

## **ТҮРЭЭСИЙН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА** **/Залуус эрүүл мэнд төв ТББ/**

Нэг. Ажлын байрны шаардлага

1.1 Ажлын байр Улаанбаатар хот, Баруун 4 замаас Зүүн зам хооронд байрлалтай, нийслэлийн 9 дүүргээс ирж үйлчлүүлэхэд нийтийн тээврийн үйлчилгээтэй ойр байх;

1.2 Шинээр баригдсан барилга бол зөвхөн тус барилгыг хүлээн авсан улсын комиссын дүгнэлтийг ирүүлэх;

1.3 Оффис үйлчилгээний зориулалттай, оффисын ажилд нийцэхүйц орчин үеийн шийдэл бүхий байх, үзэгдэх орчин сайтай, техникийн болон эрүүл ахуйн, аюулгүй байдлын шаардлага хангасан байх;

1.4 Тендерт оролцогч нь тухайн байрны өмчлөгч байх;

1.5 Ажлын байрны нийт талбайн хэмжээ нь 230 м.кв-аас багагүй байх, үүнд:

- оффисын өрөө 100м.кв-аас багагүй хэмжээтэй
- Зочин хүлээн авах уулзалтын хэсэг 25-28м.кв хэмжээтэй байх
- Угтах үйлчилгээний зориулалтын хэсэг нь 15-18м.кв хэмжээтэй байх;
- Аж ахуйн болон бараа материал агуулах зориулалтаар ашиглаж болох 4м.кв-аас доошгүй өрөө, тасалгаатай байх;
- Зөвлөгөө өгөх өрөө 25м.кв хэмжээтэй
- Цайны өрөө 6м.кв хэмжээтэй
- Сорьц цуглуулах өрөө 6м.кв хэмжээтэй
- Ажлын байр байрлаж буй давхарт эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөтэй, халуун, хүйтэн устай, нийтлэг шаардлага хангасан байх;

1.6 Ажлын байр 3-аас дээш давхарт байрладаг бол нэг удаагийн суултаар 6-аас дээш хүний багтаамжтай 1,000 кг-аас дээш даацын лифттэй байх;

1.7 Ажлын байрны зохион байгуулалт бүхий иж бүрэн тоноглогдсон ерөнхий агааржуулагч, давхар бүрт нэгдсэн эйр кондишнтэй байх;

1.8 Тухайн байрны дотор талбайд түрээслэгч байгууллагын хаяг, лого байршуулах талбайтай байх;

1.9 Ажлын байр байрлах давхарт интернетийн сүлжээний оролттой байх (RJ45 wall box)

1.10 Давхар хооронд болон өрөө хооронд холбогдсон дотоод сүлжээний сувагчлалтай байх;

1.11 Техникийн серверийн өрөөтэй, техникийн зориулалтын шалтай байх;

1.12 Давхар бүрт өндөр хүчин чадал бүхий харуул хамгаалалтын хяналтын камерийн системтэй байна.

1.13 Өрөөнүүдэд тавигдсан халаалтын радиатор тохируулга, термостаттай байх.

1.14 Өрөө тасалгааны гэрэлтүүлэг стандартын шаардлагад нийцсэн хангалттай хүрэлцэхүйц тод тусгалтай, эвдрэл сааталгүй байх.

1.15 Ажлын байрны гадна талд ажилчдын автомашин байрлах авто зогсоолтой байх, авто зогсоол нь харилцагч байгууллага болон зочид ирэхэд хангалттай /3-с дээш/ хүрэлцэхүйц байх;

Хоёр. Байр түрээслүүлэгч нь гэрээт хугацаанд доорх ажил үйлчилгээг бүрэн хариуцна

2.1 Ажлын байрны бүхий л урсгал засвар үйлчилгээг бүрэн хариуцна.

2.2 Үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой эвдрэл, засвар үйлчилгээг тухай бүр тохирсон хугацаанд багтаан хийж гүйцэтгэнэ.

2.3 Түрээслүүлэгч нь цахилгаан, сантехникийн болон засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх мэргэжлийн ажилтантай байна.

2.4 Түрээслүүлэгч нь барилгын гадна тал, нийтийн эзэмшлийн талбай, цонх, лифт, шатны цэвэрлэгээг бүрэн хариуцна.

Гурав. Байрны харуул хамгаалалт, цахилгаан, галын аюулгүй байдал

3.1 Байрны шат, хонгилд галын аюулаас урьдчилан сэргийлэх багаж хэрэгсэл, дохиолол, галын хор зэргийг байршуулсан, гал унтраах анхан шатны багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байх ба байгалийн гамшиг, аюул учирсан тохиолдолд нүүлгэн шилжүүлэх аваарын гарцтай байх;

3.2 Ажлын байрны аюулгүй байдлыг бүрэн хариуцах 24 цагийн нэгдсэн харуул хамгаалалттай байх;

3.3 Барилгын үндсэн дэд бүтэц болон байранд эвдрэл гэмтэл гарсан нөхцөлд нэн даруй үйл ажиллагааг хэвийн болгох, түрээслүүлэгчийн буруугаас үүдэлтэй байгууллагын үйл ажиллагаа саатвал тухайн хохирлыг түрээслүүлэгч тал нөхөн барагдуулна.

3.4 Цахилгааны монтаж, газардуулах байгууламжид засвар үйлчилгээ, хэмжилт туршилт хийлгэж норм хэмжээнд оруулсан акт протоколтой байх, хэт хүчдэл, богино залгааны гүйдлээс хамгаалах тоноглолоор цахилгааны хуваарилах самбарууд тоноглогдсон байна.

3.5 Цахилгааны монтаж, сүлжээ ажлын онцлогт тохирсон, ачаалал даах чадвартай байна